



Техникийн өгөгдлийн хуудас
LOCTITE® 577™

20024 оны 5 сар

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЙЛБАР

LOCTITE® 577™ бүтээгдэхүүний тодорхойлолтууд:

Технологи	Акрил
Химийн бодисын төрөл	Диметакрилат эфир
Харагдах байдал (бэхжээгүй байхдаа)	Шар өнгийн зуурмаг
Гэрэлтэх чадвар	Хэт яагаан туяанд гэрэлтэнэ ^{LMS}
Харагдах байдал (хэлбэр)	Наалдамхай
Бүрэлдэхүүн	Нэгэн төрөл
Наалдамхай чанар	Өндөр thixotropic
Бэхжилт	Хүчилтөрөгчгүй орчин
Бүрэн бэхжих	Идэвхжүүлэгч
Хэрэглээ	Эрэг болт бэхжүүлэх
Хүч чадал	Дунд зэрэг

LOCTITE® 577™ нь урьдчилан залгасан метал хоолой болон бэхэлгээг битүүмжлэх, бэхлэхэд зориулагдсан материал юм. Энэ бүтээгдэхүүн гадаргууг нь идэвхжүүлэх шаардлагагүй зэвэрдэггүй ган дээр түрхэхэд онцгой тохиромжтой. Энэ бүтээгдэхүүн угсарч байгаа эд ангиудын хооронд хүчилтөрөгчгүй орчинд ормогц бэхэжих ба цохилт, чичиргээнээс болж сулрах, шингэн алдахаас сэргийлнэ. Энэ LOCTITE® 577™-ийн thixotropic – (хугацаа ба орчноос шалтгаалж наалдамхай чанар нь өөрчлөгддөг) шинж чанар нь түүнийг эд ангийн гадаргууд түрхэсний дараа үүсэх гоожилтыг багасгана. LOCTITE® 577™ бэхжиж бат бөх болох ба гууль, зэс мэт идэвхтэй металаас гадна зэвэрдэггүй ган болон өнгөлсөн гадаргуутай идэвхгүй материалд ч ашиглах боломжтой юм. Үүнийг 0.25 мм хүртэл зайтай гадаргад болон өндөр хэмд ашиглаж болохоос гадна мөн бохирдсон гадаргууд ч ашиглаж болно. Энэ бүтээгдэхүүн янз бүрийн тос, үүний дотор метал огтлох, тослох, зэврэлтээс хамгаалах буюу багасгах (corrosion inhibitors), цэвэрлэх (гадаргуу идэвхжүүлэх-surfactants) шингэнээр бага зэрэг бохирдсон гадарга дээр ч бэхэждэг байна.

Олон улсын хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт - NSF International

Худалдаа, орон сууцны үндны усны хангамжийн системд (820C хүртлэх хэмтэй) шиглах зөвшөөрөл ANSI/NSF Standard 61 бүхий бүтээгдэхүүн юм. NSF олон улсын NSF-ийн P1 ангилалд бүртгүүлсэн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг газар болон түүний эргэн тойронд хүнсний бүтээгдэхүүнд хүрэх боломжгүй нөхцөлд битүүмж болгон ашиглах юм.

Жич: Энэ бол бүс нутгийн зөвшөөрөл юм. Дэлгэрэнгүй мэдээлэл, тодруулга авахын тулд орон нутгийн Техник үйлчилгээний төвтэй холбогдоно уу.

Австралийн хийн холбооны 4787 III ангиллын гэрчилгээгээр батлагдсан байна. Энэ нь -10°C-ээс 135 °C-ийн хэмд 2000 кПа, ажлын даралтад хэрэглэх заавартай байна. **Тэмдэглэл:** Энэ бол бүс

нутгийн зөвшөөрөл юм. Дэлгэрэнгүй мэдээлэл, тодруулга авахыг хүсвэл орон нутгийн Техник үйлчилгээний төвтэй холбогдоно уу.

EN 751-1

1, 2, 3-р бүлгийн хий, халуун устай харьцах резьбатай металл холболтыг битүүмжлэх материал; 1-р хэсэг: Анаэробик холболтын нэгдлүүд.

LOCTITE® 577™ -ийг дээрх стандартын Н ангиллын нэгдлүүдийн шалгуурт нийцүүлэн туршсан ба DVGW (Ус ба хийн аж үйлдвэрийн салбарын стандарт тогтоодог байгууллага) –ийн зөвшөөрөл авсан байна.

Устөрөгчийн гэрчилгээтэй цавуу

LOCTITE® 577™ -ийг туршин үзэхэд GASTEC QA (Хийн аж үйлдвэрийн стандартын шаардлагуудыг хянан мөрдүүлэх байгууллага) шаардлагад нийцэж Approval 214 (AR-214)-зөвшөөрөл авсан байна.

Жич: Энэ бол бүс нутгийн зөвшөөрөл юм. Дэлгэрэнгүй мэдээлэл, тодруулгыг авахын тулд орон нутгийн Техник үйлчилгээний төвтэй холбогдоно уу.

БЭХЖЭЭГҮЙ МАТЕРИАЛЫН НИЙТЛЭГ ШИНЖ ЧАНАР

Хувийн гравитац - Specific Gravity @ 25 °C

1.1

Наалдамхай чанар – Viscosity, Brookfield - RVT, 25°C , mPa·s (cP):

Spindle 6, speed 2.5 rpm,

100,000


Spindle 6, speed 20 rpm,

24,500

БЭХЖИХ НИЙТЛЭГ ТӨЛӨВ


Бэхжих хурд ба материалын гадаргуугийн хамаарал

Бэхжих хурд нь ашигласан материалын гадаргуугаас (substrate) хамаарна. Доорх графикт M10 хэмжээтэй ган гайк, боолтны ховхорч хөдлөх хүч цаг хугацаанаас хэрхэн хамаардгийг ISO 10964 стандартын дагуу өөр өөр материалтай харьцуулж туршсан үр дүнг харуулав.




Бэхжих хурд ба эд ангиудын нийлэх хоорондын зайн хамаарал

Бэхжих хурд нь эд ангиудын нийлэх хоорондын зайнаас хамаарна. Энэ зай нь бэхлэгээний болтуудын резьбаны алхам, болтны төрөл, чанар, хэмжээ зэргээс хамаарна. Дараах графикт янз бүрийн шпилька ба нүхэн дэх зайнд үүсэх шилжилийн хүч цаг хугацаанаас хэрхэн хамаардгийг ISO 10123 стандартын дагуу туршсан харуулав.




Бэхжих хурд ба температурын хамаарал

Бэхжих хурд нь дулааны хэмээс хамаарна. Доорх зурагт энэ бүтээгдэхүүнийг түрхэж тодорхой хугацаанд бэхжүүлсэн, M10 хэмжээтэй, ган гайк болон болтны хөдлөж эргэх хүч янз бүрийн температурт хэрхэн өөрчлөгдөж байгааг ISO 10964 стандартаар шалгажээ.



Бэхжих хурд ба идэвхжүүлэгчийн хамаарал

Бэхжих хурд хэт удаан байх буюу эд ангиудын хоорондын зай их том байх нөхцөлд бэхжих үйл явцыг хурдасгахын тулд идэвхжүүлэгч хэрэглэж болно. Доорх зурагт M10 хэмжээтэй, цайрын дихромт ган гайк ба болтонд SF 7471™, SF 7649™ SF 7091™ төрлийн идэвхжүүлэгч хэрэглээд тэдний ховхорч эргэх хүчийг хугацаанаас хэрхэн хамаардгийг ISO 10964 стандартаар харуулжээ.



БЭХЖҮҮЛСЭН МАТЕРИАЛЫН НИЙТЛЭГ ШИНЖ ЧАНАР

Физик шинж чанар

Хувийн дулаан - Specific Heat, kJ/(kg·K)		2.0
Сунаж тасрах хүчний хязгаар - Tensile Strength,	Nmm ² (psi)	1.3 (190)
Суналт даах чадварын модуль - Tensile Modulus , ISO 37	N/mm ² (psi)	168 (24,350)

БЭХЖҮҮЛСЭН МАТЕРИАЛЫН НИЙТЛЭГ ТӨЛӨВ

Наалдамхай (Цавуулаг) шинж чанар

24 цагийн турш 22°C хэмд бэхжүүлсэн

Ховхорч эргэх хүч – Breakaway Torque, ISO 10964:

M10 хэмжээтэй ган гайк ба болт	Nm (lb*in)	33 (295)
M10 хэмжээтэй гуулин гайк ба болт	Nm (lb*in)	23 (205)
M10 хэмжээтэй цайр дихром гайк ба болт	Nm (lb*in)	20 (175)
M10 хэмжээтэй зэвэрдэггүй ган гайк ба болт	Nm (lb*in)	15 (135)
M10 хэмжээтэй цайрын фосфат гайк ба болт	Nm (lb*in)	30 (265)
M6 хэмжээтэй ган гайк ба болт	Nm (lb*in)	7 (62)
M16 хэмжээтэй ган гайк ба болт	Nm (lb*in)	69 (615)
3/8x16 хэмжээтэй ган гайк (grade 2) ба		

болт (grade 5)	Nm (lb*in)	33 (295)
Ховхорч эргэх хүч – Prevail Torque, ISO 10964:		
M10 хэмжээтэй ган гайк ба болт	Nm (lb*in)	2.5 (22)
M10 хэмжээтэй гүүлин гайк ба болт	Nm (lb*in)	1.3 (12)
M10 хэмжээтэй цайр дихром гайк ба болт	Nm (lb*in)	3.7 (33)
M10 хэмжээтэй зэвэрдэггүй ган гайк ба болт	Nm (lb*in)	1.9 (17)
M10 хэмжээтэй цайрын фосфат гайк ба болт	Nm (lb*in)	1.8 (16)
M6 хэмжээтэй ган гайк ба болт	Nm (lb*in)	0.7 (6.2)
M16 хэмжээтэй ган гайк ба болт	Nm (lb*in)	7.5 (66)
3/8x16 хэмжээтэй ган гайк (grade 2) ба болт (grade 5)	Nm (lb*in)	3.8 (34)
Урьдчилан 5 Nm хүртэл сүлласны дараа эргүүлж суллах хүч – Breakloose Torque, ISO 10964, Pre-torqued to 5 N·m:		
M10 хэмжээтэй ган гайк ба болт	Nm (lb*in)	27 (240)
Урьдчилан 5 Nm хүртэл сүлласны дараа Ховхорч эргэх мах. хүч – Max.Prevail Torque, ISO 10964, pre-torqued to 5 Nm:		
M10 хэмжээтэй ган гайк ба болт	Nm (lb*in)	2.0 (18)
Шахалтаар шилжүүлэх хүч – Compressive Shear Strength, ISO 10123:		
Ган шпилька ба нүх	N/mm ² (psi)	5 (725)
Нэг долоо хоногийн турш 22 ⁰ C хэмд бэхжүүлсэн		
Урьдчилан 5 Nm хүртэл сүлласны дараа эргүүлж суллах хүч – Breakloose Torque, ISO 10964, Pre-torqued to 5 N·m:		
M10 хэмжээтэй цайрын фосфат гайк ба болт	Nm (lb*in)	30 (265)


ОРЧИН ТОЙРНЫ НӨХЦӨЛД ТЭСВЭРТЭЙ БАЙДАЛ

Нэг долоо хоногийн турш 22⁰C хэмд бэхжүүлсэн

Урьдчилан 5 Nm хүртэл сүлласны дараа эргүүлж суллах хүч –

Breakloose Torque, ISO 10964, Pre-torqued to 5 N·m: M10 хэмжээтэй цайрын фосфат гайк ба болт

Дулаан тэсвэрлэх хязгаар -Hot Strength




Хүйт тэсвэрлэх хязгаар

Энэ бүтээгдэхүүнийг -75°C хэмд туршсан ба үүнээс ч доош хэмийг тэсвэрлэж болзошгүй. Тэхдээ үүнийг туршаагүй болно.

Халуунд ховхорч салах дулааны хэм - Heat Aging

Халуунд ховхорч салах чадварыг нь 22 °C хэмээс эхлэн халуунд хэр удаан тэсэх хугацааны хамаарлаар туршиж харуулжээ.



Химийн бодис/Уусгагч бодист тэсвэртэй байдал

Дараах бодисуудыг заасан хэм хүртэл халаагаад хэр тэсвэртэй болохыг нь 22°C хэмийн халуунд туршиж тодорхойлжээ.

Орчин	°C	Үндсэн чадварын хувь, %		
		100 цаг	500 цаг	1000 цаг
Ацетон	22	95	65	70
Дизелийн банканд нэмдэг шингэн DEF (AdBlue®)	22	125	125	130
Тоормосны шингэн (DOT 4)	22	115	115	120
Этанол	22	110	90	90
Моторын тос (5W30-Synthetic)	125	120	130	135
Хар тугалагагүй бензин	22	115	105	105

Ус ба гликол 50/50	87	105	95	90
Био дизель В100	22	105	115	115
Этанол түлш Е85	22	100	90	90

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэ бүтээгдэхүүнийг дан хүчилтөрөгч/хүчилтөрөгч ихтэй системд хэрэглэхэд зохимжгүй бөгөөд хлортой юмуу хүчтэй исэлдүүлэгч материалуудыг хааж тусгаарлах зорилгоор ашиглаж болохгүй. Эдгээр бүтээгдэхүүнийг ашиглахдаа баримтлах мэдээллийг Аюулгүй ажиллагааны дагалдах хуудаснаас үзнэ үү.

Аюулгүй ажиллагааны өгөгдлийн хуудас

Усаар угааж цэвэрлэх систем хэрэглэдэг орчинд ажиллах эд ангиудыг нийлүүлж бэхлэх бол уг угаах уусгагч шингэнээ наалдамхай материалтай зохицох эсэхийг шалгах нь чухал юм. Учир нь зарим тохиолдолд тэрхүү угаах уусмал нь наалдамхай бодисын бэхжилтэнд нөлөөлдөг байна.

Энэ бүтээгдэхүүнийг пластик (ялангуяа даралт даахгүй хагарч болох термопластик) материалд хэрэглэж болохгүй. Тийм учраас хэрэглэгчидэд энэ бүтээгдэхүүнийг тухайн материалд хэрэглэж болох эсэхийг шалгаж байхыг зөвлөж байна.

Хэрэглэх заавар:

Угсрахдаа:

1. Сайн үр дүнд хүрэхийн тулд эд ангиудынхаа гадна болон дотор гадаргууг LOCTITE®-ын бодис хэрэглэн сайтар цэвэрлээд хатаах хэрэгтэй.
2. Хэрэв эд ангиуд нь идэвхгүй метал юмуу бэхжих хугацаа нь хэт их бол бэхэлгээний боолтны бүх уртыг LOCTITE® SF 7471™ or LOCTITE® SF 7649™ бүтээгдэхүүнээр шүршээд хатаах хэрэгтэй.
3. Энэ бүтээгдэхүүнийг болтныхоо үзүүрийн резьбанаас бусад бүх хэсэгт эргэн тойронд түрхэнэ. Тэхдээ болтныхоо резьбаны гүн болон нүх сүвд ортол дарж түрхэнэ. Хол алхамтай резьба болон нүх сүвтэй болт хэрэглэх бол болтноосоо гадна эм эрэгний дотор талын резьбаны эргэн тойронд бас түрхэнэ.
4. Энэ ажлыг гүйцэтгэхдээ үйлдвэрлэгчийн зөвлөмж, журмыг мөрдөн стандартын багажаар, заасан хэмжээгээр нь чангалах хэрэгтэй.
5. Зохих ёсоор чангалсан бэхэлгээ дунд зэргийн даралт өгөхөд шууд бэхжих болно. Харин 24 цагаас багагүй хугацаагаар бэхжүүлсэн тохиолдолд хамгийн өндөр даралт, уусгагч бодис тэсвэрлэх чадвартай болно.

Эд ангиудаа задлахдаа:

1. Стандартын багаж төхөөрөмжөөр задлах хэрэгтэй.
2. Хэрэв стандартын гар багажаар тайлах боломжгүй хэт урт буюу нэг дюймээс илүү бүдүүн болт буюу гайкийг тэр хавьд нь 250⁰ С хүртэл халаагаад хөрөхөөс нь өмнө тайлах хэрэгтэй.

Бодисыг цэвэрлэх

1. Бэхжиж хатсан бодисыг LOCTITE® уусгагчаар дэвтээгээд ган сойзоор сойздон цэвэрлэж болно.

Хадгалалт

Эдгээр бүтээгдэхүүнийг хуурай газар битүүмжилсэн контайнерт хадгална. Бүтээгдэхүүний хадгалалтын горимын мэдээллийг контайнер дээрх шошгонд үзүүлсэн байж болно.

Хадгалалтын тохиромжтой нөхцөл: 8°C - 21°C. Бүтээгдэхүүнийг 8°C-аас доош юмуу 28°C-с дээш хэмд хадгалах нь түүний чанарт сөрөг нөлөөлж болзошгүй.

Контайнерээс гаргаж авсан бүтээгдэхүүн ашиглалтын явцад бохирдож болно. Иймээс нэгэнт гаргаж авсан бүтээгдэхүүнийг эргүүлж контайнерт нь хийж болохгүй. Бохирдсон болон хадгалалтын журамд зааснаас өөр орчинд хадгалсан бүтээгдэхүүний талаар Хенкел корпораци хариуцлага хүлээхгүй. Хэрэв нэмэгдэл мэдээлэл шаардлагатай бол ойр орших Техникийн үйлчилгээний төв юмуу Хэрэглэгчид үйлчлэх төлөөлөгчийн газарт хандах хэрэгтэй.

Хувиргалтууд

$$(^{\circ}\text{C} \times 1.8) + 32 = ^{\circ}\text{F}$$

$$\text{kV/mm} \times 25.4 = \text{V/mil}$$

$$\text{mm} / 25.4 = \text{inches}$$

$$\mu\text{m} / 25.4 = \text{mil}$$

$$\text{N} \times 0.225 = \text{lb}$$

$$\text{N/mm} \times 5.71 = \text{lb/in}$$

$$\text{N/mm}^2 \times 145 = \text{psi}$$

$$\text{MPa} \times 145 = \text{psi}$$

$$\text{N}\cdot\text{m} \times 8.851 = \text{lb}\cdot\text{in}$$

$$\text{N}\cdot\text{m} \times 0.738 = \text{lb}\cdot\text{ft}$$

$$\text{N}\cdot\text{mm} \times 0.142 = \text{oz}\cdot\text{in}$$

$$\text{mPa}\cdot\text{s} = \text{cP}$$

Тэмдэглэл:

Энэхүү Техникийн Мэдээллийн Хүснэгтэд (TDS) өгөгдсөн мэдээлэл, түүний дотор бүтээгдэхүүнийг ашиглах, хэрэглэх зөвлөмжүүд нь энэхүү TDS-ийн огнооны бүтээгдэхүүний талаарх бидний мэдлэг, туршлагад үндэслэсэн болно. Бүтээгдэхүүн нь янз бүрийн хэрэглээтэй байж болохоос гадна таны орчин дахь бидний хяналтаас гадуур өөр өөр хэрэглээ, ажлын нөхцөлтэй байж болно. Тиймээс Henkel нь таны хэрэглэж буй үйлдвэрлэлийн үйл явц, нөхцөл, түүнчлэн төлөвлөсөн хэрэглээ, үр дүнд манай бүтээгдэхүүн тохирох эсэхийг хариуцахгүй. Манай бүтээгдэхүүний ийм тохиромжтой эсэхийг баталгаажуулахын тулд бид танд өмнөх туршилтаа хийхийг зөвлөж байна.

Техникийн мэдээллийн хуудасны мэдээллийн талаархи аливаа хариуцлага, бидний хайхрамжгүй байдлаас үүдэлтэй амь насаа алдах, бие махбодид гэмтэл учруулахаас бусад тохиолдолд холбогдох бүтээгдэхүүнтэй холбоотой бусад бичгээр эсвэл аман зөвлөмж(үүд) хамаарахгүй.

Бүтээгдэхүүнийг Henkel Belgium NV, Henkel Electronic Materials NV, Henkel Nederland BV, Henkel Technologies France SAS болон Henkel France SA зэрэг компаниуд нийлүүлсэн тохиолдолд дараахь зүйлийг нэмж анхаарна уу.

Хэдийгээр ямар ч хуулийн үндэслэлээр Henkel хариуцлага хүлээх тохиолдолд Henkel-ийн хариуцлага ямар ч тохиолдолд холбогдох хүргэлтийн дүнгээс хэтрэхгүй.

Бүтээгдэхүүнийг Henkel Colombiana, S.A.S. нийлүүлсэн тохиолдолд дараахь мэдэгдлийг дагаж мөрдөнө.

Энэхүү Техникийн Мэдээллийн Хүснэгтэд (TDS) өгөгдсөн мэдээлэл, түүний дотор бүтээгдэхүүнийг ашиглах, хэрэглэх зөвлөмжүүд нь энэхүү TDS-ийн огнооны бүтээгдэхүүний талаарх бидний мэдлэг, туршлагад үндэслэсэн болно. Бүтээгдэхүүн нь янз бүрийн хэрэглээтэй байж болохоос гадна таны орчин дахь бидний хяналтаас гадуур өөр өөр хэрэглээ, ажлын нөхцөлтэй байж болно. Тиймээс Henkel нь таны хэрэглэж буй үйлдвэрлэлийн үйл явц, нөхцөл, түүнчлэн төлөвлөсөн хэрэглээ, үр дүнд манай бүтээгдэхүүн тохирох эсэхийг хариуцахгүй. Манай бүтээгдэхүүний ийм тохиромжтой эсэхийг баталгаажуулахын тулд бид танд өмнөх туршилтаа хийхийг зөвлөж байна.

Техникийн мэдээллийн хуудасны мэдээллийн талаархи аливаа хариуцлага, бидний хайхрамжгүй байдлаас үүдэлтэй амь насаа алдах, бие махбодид гэмтэл учруулахаас бусад тохиолдолд холбогдох бүтээгдэхүүнтэй холбоотой бусад бичгээр эсвэл аман зөвлөмж(үүд) хамаарахгүй.

Бүтээгдэхүүнийг Henkel корпораци эсвэл HenkelCanada корпораци нийлүүлсэн тохиолдолд дараахь мэдэгдлийг хэрэглэнэ.

Энд агуулагдсан өгөгдөл нь зөвхөн мэдээллийн зорилгоор хийгдсэн бөгөөд найдвартай гэдэгт итгэлтэй байна. Арга, арга барилыг нь хянах боломжгүй бусдын олж авсан үр дүнд бид хариуцлага хүлээхгүй. Энд дурдсан үйлдвэрлэлийн аргууд нь хэрэглэгчийн зорилгод нийцэж байгаа эсэхийг тодорхойлж, өмч хөрөнгө болон эд хөрөнгийг хамгаалах үүднээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах нь хэрэглэгчийн үүрэг юм. хүмүүстэй харьцах, ашиглахад учирч болзошгүй аливаа аюулын эсрэг.

HenkelCorporation нь Henkel Corporation-ын бүтээгдэхүүнийг худалдах эсвэл ашиглахтай холбоотой зарагдах эсвэл тусгай зориулалтын дагуу ашиглах баталгаа зэрэг бүх баталгааг үгүйсгэдэг. Henkel корпораци нь алдагдсан ашгийг оролцуулан аливаа төрлийн үр дагавар болон санамсаргүй хохирлыг хариуцахаас тусгайлан татгалздаг.

Төрөл бүрийн процесс эсвэл найрлагыг энд хэлэлцэх нь бусдын эзэмшиж буй патентын ноёрхлоос ангид байх эсвэл Henkel корпорацийн патентын дагуу ийм үйл явц эсвэл найрлагыг хамарсан лиценз гэж тайлбарлаж болохгүй. Ирээдүйн хэрэглэгч бүр өөрийн санал болгож буй програмаа давтан ашиглахын өмнө энэ өгөгдлийг гарын авлага болгон ашиглахыг зөвлөж байна. Энэ бүтээгдэхүүн нь нэг буюу хэд хэдэн Америкийн Нэгдсэн Улс эсвэл гадаадын патент эсвэл патентын мэдүүлэгт хамрагдаж болно.